



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/91.

Хэрлэн сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Залуучуудын хөгжлийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2, 58.2.17, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2, 58.2.17, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам"-ын 2.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2018 оныг Гэр бүлийн хөгжлийг дэмжих жил болгон зарласантай холбогдуулан Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас санаачлан сум орон нутгийн иргэдэд байгууллагын үйл ажиллагааг танилцуулах, нөлөөллийн ажлын холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулснаар залуучуудын өмнө тулгамдсан асуудлыг тодорхойлж цаашдын үйл ажиллагааны чиглэлээ тогтоох зорилготойгоор Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран "Залуус хөгжлийн эхлэл" багц арга хэмжээг 2018 оны 03 сарын 09-нөөс 03 сарын 27-ны өдрийг хүртэл хугацаанд 18 сумдын хэмжээнд зохион байгуулахад Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт санхүүгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Санхүүгийн дэмжлэгт шаардагдах 1000000 /нэг сая/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн болзошгүй зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар /Ж.Ганбаатар/-т тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА